

**Mongolian language for foreigners – Week 16**  
**Lecture №16**

**Сэдэв: Монголчуудын уламжлал тоглоом, наадгай**  
**Topic: Mongolian traditional games**

**Сонсох, ярих, унших, бичих чадварыг дээшлүүлэх**  
**listening, speaking, reading, writing**

**Mongolian National University Arts And Culture**  
**Professor, Basbish.S**

## Хичээлийн агуулга - Lecture content

---

1. Өмнөх хичээлийн бататгал- Reviewing pervious learning
2. Монголчуудын уламжлалт тоглоом, наадгай– Mongolian traditional games
3. Дасгал ажлууд- Exercises
4. Шинэ үг хэллэгүүд- New words
5. Гэрийн даалгавар - Homework

# Монголчуудын тоглоом, наадгай Mongolian games

*Дасгал 1. Асуултыг уншаарай. - Read the questions.*

1. Монгол тоглоом тоглож үзсэн үү?  
Таалагдсан уу? Яагаад?
2. Ямар ямар монгол тоглоом байдаг вэ?



(Мөнхцэцэг, Г., Орхон,Б, 2021, хууд. 113)

Ариун-Эрдэнэ, Н. (2020, September 17). Шагайн тоглоом [Photograph].  
[www.maamuu.mn. https://www.maamuu.mn/?p=13621](https://www.maamuu.mn/?p=13621)

Өмнөх хичээлийн бататгал буюу гэрийн даалгавар  
Reviewing pervious learning and homework

Мэдлэг шалгах тест

1. Хүүхдэд эхээс төрөх үед толгойд нь ургасан байсан үсийг \_\_\_\_\_ гэж нэрлэдэг.  
А. үс                       Б. даахь                      В. ноос                      Г. хялгас
2. Хүүхдийн даахийг анх авахдаа \_\_\_\_\_, сайн өдрийг тусгайлан сонгож, авга, нагац, ах, эгч нар болон бусад хамаатан садан, хүндтэй зочдыг урьж, идээ засан ёслол хийдэг.  
А. дуртай                      Б. таалагдсан                      В. харш                       Г. ивээл
3. Хүүхдийн даахинд \_\_\_\_\_ хүн эхэлж гар хүрнэ.  
А. хамгийн үзэсгэлэнтэй                      Б. өндөр настай  
 В. ивээл жилтэй                      Г. сайхан хувцастай
4. Эрэгтэй хүүхдийг \_\_\_\_\_ буюу гурав, тав, долоон настайд нь, эмэгтэй хүүхдийг \_\_\_\_\_ буюу хоёр, дөрөв, зургаан настайд нь даахийг нь авдаг.  
 А. сондгой, тэгш                      Б. тэгш, сондгой                      В. сондгой, сондгой                      Г. тэгш, тэгш
5. Хүүхдийн даахины найрын ширээнд заавал байх ёстой идээ бол \_\_\_\_\_ буюу сүү, цагаан идээ. Ирсэн хүн бүр энэ идээнээс хамгийн түрүүнд амсдаг заншилтай.  
А. тараг                      Б. айраг                       В. цагаалга                      Г. хоормог

Өмнөх хичээлийн бататгал буюу гэрийн даалгавар  
Reviewing pervious learning and homework

6. Хүүхдийн дахийг авахдаа ивээл жилтэй хүн хүүхдэд эхлээд \_\_\_\_\_ амсуулж, даахинд нь модон хутга хүргэн ёс үйлдэнэ.  
 А. сүү                      Б. тараг                      В. айраг                      Г. цай
7. Хүүхдийн даахинд гар хүрсний дараа хүүхдэд сайн сайхныг бэлгэдсэн \_\_\_\_\_ хэлж, бэлэг өгнө.  
 А. ерөөлийн үг                      Б. зүйр үг                      В. тууз                      Г. хадаг
8. Ёслол дууссаны дараа хүүхдийн үлдсэн бүх үсийг \_\_\_\_\_ өмнө авна.  
А. нар мандахаас                       Б. нар жаргахаас  
В. сар мандахаас                      Г. сар жаргахаас
9. Хүүхдийн даахь үргээх найранд \_\_\_\_\_, \_\_\_\_\_ хэрэглэдэггүй.  
А. цагаан идээ                      Б. мах, өөх                      В. жимс, ногоо                       Г. архи, дарс
10. Хүүхдийн даахинд гар хүрсэн хүмүүс хүүхдийн “толгойг мялааж” халзан цагаан \_\_\_\_\_ эсвэл хурга амладаг ёс бий.  
А. морь                       Б. хонь                      В. ямаа                      Г. үхэр

## Монголчуудын тоглоом, наадгай Mongolian games

---

*Шинэ үг хэллэгүүдийг цээжилж, утгыг ойлгоорой.  
Memorize the new vocabularies and understand the meaning*

1. Ажигч гярхай – sharp - eyed
2. Аман тоглоом – games played with words
3. Бай онох – hit the target
4. Гар, хуруугаар тоглох тоглоом – games played with hands and fingers
5. Гарын булчин шөрмөс – muscle and sinew of hands
6. Гэр барих тоглоом – a game to build “gher” Mongolian traditional dwelling
7. Дэг журамтай - principled
8. Задлах – to dismantle
9. Нүдний хараа сайжруулах – to improve eyesight
10. Онъсон тоглоом – assembly puzzle
11. Өв сан - heritage

## Монголчуудын тоглоом, наадгай Mongolian games

---

*Шинэ үг хэллэгүүдийг цээжилж, утгыг ойлгоорой.  
Memorize the new vocabularies and understand the meaning*

12. Өнхөрүүлэх – to roll down

13. Таван хошуу мал – five kinds of farm  
animals /horse, camel, cow, sheep, goat/

14. Угрсах – to assemble

15. Ур хийц - craftsmanship

16. Хөдөлгөөнт тоглоом – outdoor games

17. Хөлөгт тоглоом – board games

18. Чулуун тоглоом – games to play with stones

12. Соёлын өв – cultural heritage

13. Сэтгэхүй хөгжлүүлэх – to develop a growth  
mindset

14. Тоглоом наадгай – game and toys

15. Түгээмэл - common

16. Шагайн тоглоом – games to play with ankle  
bones

## Монголчуудын уламжлалт тоглоом, наадгай Mongolian traditional games

---

**Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.**  
**Exercise 2. Listen and fill the missing words**

**Нөхөх үгс - Choose from following words: 3000, Хүннү, нүүдэлчдийн, хүмүүжлийн, үзмэр, Чулуугаар, хэлбэр, 800, алаг мэлхий, зохион бүтээгчийн, малын, дүрс**

### Монголчуудын уламжлалт тоглоом, наадгай

Монголчуудын тоглоом наадгай нь 1)\_\_\_\_\_ амьдрал ахуйд тулгуурласан оюуны чухал соёлын өв юм. Монгол тоглоомын дотор эртний хүмүүсийн амьдрал, өдөр тутмын ажлыг шууд тусган зохиогдсон тоглоом олон байдаг. Тухайлбал, 2)\_\_\_\_\_ бай онох, чулуу өнхрүүлэн уралдуулах, чулуугаар ус алгадуулах зэрэг тоглоом нь ан агнах, араатнаас биеэ хамгаалах аргаас үүсчээ. Монголчуудын тоглоом наадгайг насанд хүрэгчдийн, хүүхэд залуучуудын гэж ангилдаг.

## Монголчуудын уламжлалт тоглоом, наадгай Mongolian traditional games

---

**Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.**  
**Exercise 2. Listen and fill the missing words**

**Нөхөх үгс - Choose from following words: 3000, Хүннү, нүүдэлчдийн, хүмүүжлийн, үзмэр, Чулуугаар, хэлбэр, 800, алаг мэлхий, зохион бүтээгчийн, малын, дүрс**

Эдгээрийг шагайн тоглоом, чулуун тоглоом, аман тоглоом, хөлөгт тоглоом, гар хуруугаар тоглох тоглоом, хөдөлгөөнт тоглоом, гэр барих тоглоом, оньсон тоглоом гэх мэтээр ангилдаг. Ардын тоглоомын санд 15 бүлгийн 3) \_\_\_\_\_ гаруй нэр төрлийн тоглоом байдаг. Монгол тоглоом нь мал сүргээ маллаж өсгөх, ан гөрөө хийх, ахмад хүнийг хүндлэх ёсонд сургах зэрэг ажил хөдөлмөр, 4)\_\_\_\_\_ чухал ач холбогдолтой. Эдгээрээс хамгийн их дэлгэрсэн зарим тоглоомын бүлгээс дурдъя.

Монголчуудын уламжлалт тоглоом, наадгай  
Mongolian traditional games

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.  
Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс - Choose from following words: 3000, Хүннү, нүүдэлчдийн, хүмүүжлийн, үзмэр,  
Чулуугаар, хэлбэр, 800, алаг мэлхий, зохион бүтээгчийн, малын, дүрс*

**Шагайн тоглоом:** Шагайгаар наадах 80 орчим төрлийн тоглоом байдаг бөгөөд эртний уламжлалтай. Шагайн тал бүр өөр өөр нэртэй. Талуудыг таван хошуу 5) \_\_\_\_\_ нэрээр оноон нэрлэсэн. Шагайгаар "шагай няслах", "алаг мэлхий өрөх", "морь уралдуулах", "шагай шүүрэх" зэргээр тоглодог. Цагаан сарын битүүний үдэш "6) \_\_\_\_\_" өрдөг. Шагайн наадгай нь хүүхдийг дэг журамтай, ажигч гярхай болгож, нүдний харааг сайжруулдаг гэж үздэг. Анд бололцохдоо шагай солилцдог байсан нь нэгэн бие мэт салшгүй байхын бэлгэдэл байжээ.

# Монголчуудын уламжлалт тоглоом, наадгай Mongolian traditional games

## Шагайн тоглоом



Oyunkham, G. (2021, January 29). Цагаан сар ба шагайн наадгай [Photograph]. unread.today.  
<https://unread.today/c/insight-lunarloyalty-upoint>



Orgio89. (2022, September 18). Алаг мэлхий шагайн тоглоом [Photograph]. mn.wikipedia.org.  
[https://mn.wikipedia.org/wiki/%D0%A8%D0%B0%D0%B3%D0%B0%D0%B9%D0%BD\\_%D0%BD%D0%B0%D0%B0%D0%B4%D0%B3%D0%B0%D0%B9#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Alag\\_melhii\\_knucklebone\\_game\\_20220926-2148.jpg](https://mn.wikipedia.org/wiki/%D0%A8%D0%B0%D0%B3%D0%B0%D0%B9%D0%BD_%D0%BD%D0%B0%D0%B0%D0%B4%D0%B3%D0%B0%D0%B9#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Alag_melhii_knucklebone_game_20220926-2148.jpg)

# Монголчуудын уламжлалт тоглоом, наадгай Mongolian traditional games

## Шагайн тоглоом



Mongolian National Broadcaster. (2017, November 24).  
Монгол шагайн үүсэл [Photograph]. [www.mnb.mn](http://www.mnb.mn).  
<https://www.mnb.mn/i/127968>



Мон судар. (2016, April 6). Шагайн тоглоом  
[Photograph]. [ikon.mn](http://ikon.mn).  
<https://ikon.mn/n/phh>

## Монголчуудын уламжлалт тоглоом, наадгай Mongolian traditional games

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.  
Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс - Choose from following words: 3000, Хүннү, нүүдэлчдийн, хүмүүжлийн, үзмэр, Чулуугаар, хэлбэр, 800, алаг мэлхий, зохион бүтээгчийн, малын, дүрс*


**Онъсон тоглоом:** Монголчууд эрт дээр үеэс жилийн дөрвөн улирлын турш нүүдэллэн амьдардаг байсан тул гэр орон, тавилга хэрэгсэл, хашаа саравчаа бүгдийг нь хялбархан задалж, угсрахаар хийдэг байжээ. Үүнээс үүдэн онъсон тоглоом үүссэн гэж үздэг. 7)\_\_\_\_\_ гүрний үед онъсон тоглоомоор тоглож байсан баримт олджээ. Энэхүү уламжлалт тоглоомыг модоор хийдэг учраас хүүхдэд ямар ч хоргүй, оюун ухааныг хөгжүүлэхээс гадна гарын булчин, шөрмөсийг ч хөгжүүлдэг. Онъсон тоглоомыг 3, 6, 9, 12, 32 модны гэх мэтээр ангилдаг. Онъсон тоглоом нь 8)\_\_\_\_\_ санаа, ур хийцээр баяждаг учраас маш олон янзын хэлбэр дүрстэй байдаг.

# Монголчуудын уламжлалт тоглоом, наадгай Mongolian traditional games

## Онъсон тоглоом



Mongolian National Broadcaster. (2023, April 14).  
Онъсон тоглоом [Photograph]. [www.mnb.mn](http://www.mnb.mn).  
<https://www.mnb.mn/i/290329>



Гантуяа, Б. (n.d.). Онъсон тоглоом [Photograph].  
[focusmedee.mn](http://focusmedee.mn).  
<http://focusmedee.mn/9634.html>

## Монголчуудын уламжлалт тоглоом, наадгай Mongolian traditional games

**Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.**  
**Exercise 2. Listen and fill the missing words**

**Нөхөх үгс - Choose from following words: 3000, Хүннү, нүүдэлчдийн, хүмүүжлийн, үзмэр, Чулуугаар, хэлбэр, 800, алаг мэлхий, зохион бүтээгчийн, малын, дүрс**

Монгол улсад оньсон тоглоомын хамгийн баялаг өв сантай хүн бол Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, шилдэг зохион бүтээгч З. Түмэн- Өлзий юм. Тэр Монголын уламжлалт оньсон тоглоомыг урлах 9) \_\_\_\_\_ төрлийн арга байдгийг тогтоон, гэрчилгээг нь авчээ. З. Түмэн- Өлзий 1955 оноос хойш нийт 5000 орчим оньс зохион бүтээж, Оюун Ухааны Олон улсын Музейг Улаанбаатар хотноо 1990 онд үүсгэн байгуулсан. Музейд Монголын болон олон улсын оньсон ба сэтгэхүй хөгжүүлэх 9000 орчим тоглоом наадгайнууд, 500 шахам шатар, хөлөгт тоглоом, 350 орчим уран зураг нийт 11000 10) \_\_\_\_\_ байдаг бөгөөд дэлхийд ховор музей гэгддэг.

## Монголчуудын уламжлалт тоглоом, наадгай Mongolian traditional games

### Оюун ухааны музей



Оюун ухааны музей [Photograph]. (2021, February 4). culture.gov.mn.  
<https://culture.gov.mn/index.php/home/nv/media/news/275>



Мягмарсүрэн, Б. (2019, October 15). Онъсон тоглоом [Photograph].  
montsame.mn. <https://montsame.mn/mn/read/203714>

Музейн захирал З.Түмэн-Өлзий шатрын хөлгийн ширээ, Сүхбаатарын хөшөө, Эрх чөлөөний хөшөө, Эйфлийн цамхаг зэргийг оньсон тоглоом болгон урлажээ. Оюун задлах оньсон тоглоомоороо Монгол дэлхийд дээгүүр байранд ордог. Рубикийн шоог эвлүүлэх нь дэлхий дээрх хамгийн хүнд тоглоом гэдэг. Харин Монголын оньсон тоглоомууд хоёроос эхлээд 600 гаруй мод оролцуулан эвлүүлдэг тул Рубикийн шооноос хэд дахин хэцүү. Рубикийн шоо зургаан талтай нэг янз байдаг бол Монголын оньсон тоглоомуудын хэлбэр хэдэн арван янз байдаг.

## Монголчуудын уламжлалт тоглоом, наадгай Mongolian traditional games

Музейн захирал З.Түмэн-Өлзий монгол тоглоомыг:

- Уях сүлжих наадам
- Хөлөгт наадам
- Хуруу гарын ба сүүдэр наадам
- Эвлэх хайчлах наадам
- Гогцоо тайлах наадам
- Ээдрээ тайлах наадам
- Онъсон тоглоом
- Оюунтүлхүүр наадам
- Ахуй төрлийн наадаан
- Илбэ шидийн наадаан гэж ангилсан.



Оюун ухааны музей [Photograph]. (n.d.). [www.touristinfocenter.mn](http://www.touristinfocenter.mn).  
[http://www.touristinfocenter.mn/cate17\\_more.aspx?ItemID=13](http://www.touristinfocenter.mn/cate17_more.aspx?ItemID=13)

## Монголчуудын уламжлалт тоглоом, наадгай Mongolian traditional games

---

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.  
Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс - Choose from following words: 3000, Хүннү, нүүдэлчдийн, хүмүүжлийн, үзмэр, Чулуугаар, хэлбэр, 800, алаг мэлхий, зохион бүтээгчийн, малын, дүрс*

Гар хуруугаар тоглох тоглоом: Монголчуудын түгээмэл тоглодог тоглоом наадгайн дотор хуруугаар тоглох тоглоом хүндтэй байр суурь эзэлнэ. Үүнд: “Дунд хуруу олох”, “Сүмбэр уул”, гар хурууны сүүдрээр 12) \_\_\_\_\_ бүтээх, “Дэмбээдэх”, “Хуруудах” гэх мэт тоглоомууд орно. Энэ нь ямар нэг тоглох хэрэглэгдэхүүн гаднаас эрж хайхгүй, өөрт бэлэн байгаа зүйлээрээ хаа байгаа газартаа, дуртай цагтаа тоглож болдгоороо нүүдэлчин Монголчуудад хамгийн их тохиромжтой тоглоом наадгай юм.

Монголчуудын уламжлалт тоглоом, наадгай  
Mongolian traditional games

---

*Дасгал 2. Сонсоод, эхийн орхигдсон үгсийг нөхөж бичнэ үү.  
Exercise 2. Listen and fill the missing words*

*Нөхөх үгс - Choose from following words: 3000, Хүннү, нүүдэлчдийн, хүмүүжлийн, үзмэр,  
Чулуугаар, хэлбэр, 800, алаг мэлхий, зохион бүтээгчийн, малын, дүрс*

Гогдоо наадам: Битүү гогцоо утсыг хоёр гарын хуруунуудаараа холбон ямар нэгэн хэлбэр дүрс гаргаэ, түүнийг нь нөгөө тоглогч нэрлэн тэр байдлаар нь авах ба хэрэв тэр байдлаар нь авч чадахгүй юмуу, утсыг орооцолдуулбал хожигдсонд тооцогдоно.

Монголчуудын уламжлалт тоглоом, наадгай  
Mongolian traditional games

---

*Дасгал 3. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.*

*Exercise 3. Discuss about following questions and review your understanding*

1. Монгол тоглоомыг юу юу гэж ангилдаг вэ?
2. Хичнээн төрлийн монгол тоглоом байдаг вэ?
3. Монгол тоглоом ямар ач холбогдолтой вэ?
4. Хичнээн төрлийн шагайн тоглоом байдаг вэ?
5. Шагайн талуудыг юугаар нэрлэсэн бэ?

Монголчуудын уламжлалт тоглоом, наадгай  
Mongolian traditional games

---

*Дасгал 3. Дараах асуултын дагуу ярилцаж, ойлголтоо шалгаарай.*

*Exercise 3. Discuss about following questions and review your understanding*

6. Шагайн тоглоом ямар ач холбогдолтой вэ?
7. Онъсон тоглоом яаж үүссэн бэ?
8. Онъсон тоглоом ямар ач холбогдолтой вэ?
9. Оюун Ухааны Олон улсын Музейг хэн, хэзээ байгуулсан бэ?
10. Оюун Ухааны Олон улсын Музейд ямар ямар төрлийн хэдэн үзмэр байдаг вэ?

Монголчуудын уламжлалт тоглоом, наадгай  
Mongolian traditional games

---

**Дасгал 4. Тохирох үгийг ашиглан өгүүлбэрийг гүйцээнэ үү.**

**Exercise 4. Please select the appropriate word and use it to complete the sentence correctly.**

**(өмнө, хойш, дараа, үеэр, дотор, хүртэл, хооронд)**

1. “100,000 шагай” өдөрлөгийн \_\_\_\_\_ манай гэр бүлийнхэн олон тоглоом сурлаа.
2. Тоглоом эхлэхий \_\_\_\_\_ тоглоомын дүрмийг хэлэлцэх ёстой.
3. Шагай таалцаж, тоглоход хүүхдүүд 0-ээс 50-ын \_\_\_\_\_ нэмж, хасаж сурдаг.
4. Манайх шагайгаа 1000 \_\_\_\_\_ цуглуулж байсан.
5. Бид нар хоёр баганын \_\_\_\_\_ шагайгаар морь уралдуулж тоглодог.
6. Хүүхдүүд өчигдрөөс \_\_\_\_\_ шагайгаар тоглож байна.
7. Тоглож дууссанахаа \_\_\_\_\_ шагайгаа тоо ёсоор нь хураагаарай.

Монголчуудын уламжлалт тоглоом, наадгай  
Mongolian traditional games

---

***Дасгал 6 А. Өгөгдсөн үгсээр холбоо үг бүтээнэ үү.  
Exercise 6 A. Match following words to its explanation.***

- |               |             |
|---------------|-------------|
| 1. Уралдаанд  | а. хожих    |
| 2. Тоглоомонд | б. байранд  |
| 3. Тулаанд    | в. түрүүлэх |
| 4. Нэгдүгээр  | г. ялах     |
| 5. Машины     | д. барих    |
| 6. Сүүл       | е. тэмцээн  |
| 7. Шатрын     | ё. уралдаан |

Монголчуудын уламжлалт тоглоом, наадгай  
Mongolian traditional games

---

**Дасгал 6 Б. Дээрх үгсийг ашиглан өгүүлбэрийг гүйцээж бичнэ үү.**

**Exercise 6 B. Please use the words provided above to complete the sentences accurately.**

1. Манай ангийн дөрвөн сурагч шатрын \_\_\_\_\_-д оролцсон.
2. 4-р сар бүр Налайх дүүрэгт спорт \_\_\_\_\_уралдаан болдог.
3. Манай баг сагсан бөмбөгийн тэмцээнд \_\_\_\_\_ орсон.
4. Тулаанч Б.Батгэрэл өрсөлдөгчөө \_\_\_\_\_-лаа.
5. Хүү маань энэ удаагийн уралдаанд \_\_\_\_\_-сан.
6. Би гэр бүлийнхнийгээ хөзөр тоглоод дандаа \_\_\_\_\_-дог.
7. Би дугуйн уралдаанд гурван удаа \_\_\_\_\_-сэн.

# Гэрийн даалгавар 1

## Homework 1

### Мэдлэг шалгах тест

- 1. Монголчуудын тоглоом наадгай нь \_\_\_\_\_ амьдрал ахуйд тулгуурласан оюуны чухал соёлын өв юм.**  
А. нүүдлийн                      Б. Суурин                      В. Орчин үеийн                      Г. Малчин
- 2. Чулуугаар бай онох, чулуу өнхөрүүлэн уралдуулах, чулуугаар ус алгадуулах зэрэг тоглоом нь \_\_\_\_\_, араатнаас биеэ хамгаалах аргаас үүсчээ.**  
А. Мал маллах                      Б. Ан агнах  
В. Жимс түүх                      Г. Ногоо тарих
- 3. Монгол ардын тоглоомын санд 15 бүлгийн \_\_\_\_\_ гаруй нэр төрлийн тоглоом байдаг.**  
А. 500                      Б. 800                      В. 1000                      Г. 1500
- 4. Шагайн наадгай нь эртний уламжлалтай бөгөөд шагайгаар наадах \_\_\_\_\_ орчим төрлийн тоглоом байдаг.**  
А. 20                      Б. 40                      В. 60                      Г. 80
- 5. Шагайн тал бүрийг \_\_\_\_\_ нэрээр оноон нэрлэсэн байдаг.**  
А. Араатан, жигүүртэн амьтдын                      Б. Гэрийн тэжээвэр амьтдын  
В. Хоёр нутагтан амьтдын                      Г. Таван хошуу малын

## Гэрийн даалгавар 1 Homework 1

6. Цагаан сарын битүүний үдэш шагайгаар “ \_\_\_\_\_ ” өрж нааддаг.  
А. Алаг мэлхий                      Б. Цоохор мэлхий  
В. Алаг бяруу                      Г. Цоохор бяруу
7. \_\_\_\_\_ найдгай нь хүүхдийг дэг журамтай, ажигч гярхай болгож, нүдний харааг сайжруулдаг гэж үздэг.  
А. чулуун                      Б. шагайн                      В. модон                      Г. төмрөн
8. Онъсон тоглоотыг модоор хийдэг учраас хүүхдэд ямар ч хор нөлөөгүй, оюун ухааныг хөгжүүлэхээс гадна гарын \_\_\_\_\_, \_\_\_\_\_ ч хөгжүүлдэг.  
А. Хумс, судсыг                      Б. Арьс, үсийг  
В. Яс, махыг                      Г. Булчин, шөрмөсийг
9. Монголчууд гар хурууны сүүдрээр \_\_\_\_\_ бүтээн нааддаг уламжлалтай.  
А. дүрс                      Б. амьтан                      В. хөдөлгөөн                      Г. хүн
10. Монгол улсад \_\_\_\_\_ тоглоомын хамгийн баялаг өв сантай хүн бол Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, шилдэг зохион бүтээгч З.Түмэн-Өлзий юм.  
А. Онъсон                      Б. Чулуун                      В. Шагайн                      Г. Модон

# Монголчуудын тоглоом, наадгай Mongolian games

---

## Гэрийн даалгавар 2 Homework 2



<https://thenounproject.com/icon/homework-3841940/>

- *Сэдэвт гарсан шинэ үг хэллэгүүдийг цээжлээрэй.  
Memorize vocabulary in the given topic*
- *Өөрийн орны тоглоом наадмын талаар бичээрэй.  
Write about the games in your country*

## НОМ ЗҮЙ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ-REFERENCES

---

Мөнхцэцэг, Г., Орхон,Б. (2021). Монгол орон судлал. Улаанбаатар: Линограф ХХК.

Баттулга, Ч (2020). Монгол орон судлал. Улаанбаатар: Удам соёл ХХК.

Ариун-Эрдэнэ, Н. (2020, September 17). Шагайн тоглоом [Photograph].

www.maamuu.mn. <https://www.maamuu.mn/?p=13621>

Оуулкхам, G. (2021, January 29). Цагаан сар ба шагайн наадгай [Photograph].

unread.today. <https://unread.today/c/insight-lunarloyalty-upoint>

Orgio89. (2022, September 18). Алаг мэлхий шагайн тоглоом [Photograph]. mn.wikipedia.org. [https://mn.wikipedia.org/wiki/%D0%A8%D0%B0%D0%B3%D0%B0%D0%B9%D0%BD\\_%D0%BD%D0%B0%D0%B0%D0%B4%D0%B3%D0%B0%D0%B9#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Alag\\_melhii\\_knucklebone\\_game\\_20220926-2148.jpg](https://mn.wikipedia.org/wiki/%D0%A8%D0%B0%D0%B3%D0%B0%D0%B9%D0%BD_%D0%BD%D0%B0%D0%B0%D0%B4%D0%B3%D0%B0%D0%B9#/media/%D0%A4%D0%B0%D0%B9%D0%BB:Alag_melhii_knucklebone_game_20220926-2148.jpg)

Mongolian National Broadcaster. (2017, November 24). Монгол шагайн үүсэл

[Photograph]. www.mnb.mn. <https://www.mnb.mn/i/127968>

Мон судар. (2016, April 6). Шагайн тоглоом [Photograph]. ikon.mn.

<https://ikon.mn/n/phh>

## НОМ ЗҮЙ, АШИГЛАСАН МАТЕРИАЛ-REFERENCES

---

Mongolian National Broadcaster. (2023, April 14). Онъсон тоглоом [Photograph].

[www.mnb.mn](http://www.mnb.mn). <https://www.mnb.mn/i/290329>

Гантуяа, Б. (n.d.). Онъсон тоглоом [Photograph]. [focusmedee.mn](http://focusmedee.mn).

<http://focusmedee.mn/9634.html>

Оюун ухааны музей [Photograph]. (2021, February 4). [culture.gov.mn](http://culture.gov.mn).

<https://culture.gov.mn/index.php/home/nv/media/news/275>

Мягмарсүрэн, Б. (2019, October 15). Онъсон тоглоом [Photograph].

[montsame.mn](http://montsame.mn). <https://montsame.mn/mn/read/203714>

Оюун ухааны музей [Photograph]. (n.d.). [www.touristinfocenter.mn](http://www.touristinfocenter.mn).


[http://www.touristinfocenter.mn/cate17\\_more.aspx?ItemID=13](http://www.touristinfocenter.mn/cate17_more.aspx?ItemID=13)

Монголчуудын тоглоом, наадгай  
Mongolian games

Дараагийн хичээл хүртэл  
баяртай!



[https://www.flaticon.com/free-icon/teacher\\_1995413](https://www.flaticon.com/free-icon/teacher_1995413)



<https://thenounproject.com/icon/lecture-1525984/>